




# СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.02 №22 (22)

ҮЙЛ ЯВДАЛ

## ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР, ЗХЖШ-ЫН ДАРГА Д.ГАНЗОРИГ НАРЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Халтмаагийн Баттулга өчигдөр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нарыг хүлээн авч уулзаж, үүрэг чиглэл өглөө.

Уулзалтын эхэнд Ерөнхийлөгч Х.Баттулга "Батлан хамгаалахын сайдтай 03 дугаар сарын 1-нд уулзаад Батлан хамгаалах салбарын сүүлийн үеийн нөхцөл

байдал, мөн вакцины талаар ярилцсан. Гэтэл сарын дараа дахин ноцтой асуудал гарч, цэргийн амь эрсэдлээ. Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах тухай заалт бий. Энэ асуудлаар яаж ажиллах гэж байна. Хүний эрхийн байгууллагуудтай хамтарч ажиллах уу?" хэмээн асууж, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн алба хаагч 03 дугаар сарын 30-нд

гэмтлийн улмаас амь насаа алдсан хэргийн талаар мэдээлэл сонсов.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр цэргийн алба хаах явцад гарч буй зөрчлүүд, гэмт хэргүүдийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдүгээрт нэгтгэл, ангиудад хяналтын камер байрлуулах, хоёрдугаарт Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн, офицеруудын дунд мэдлэг чадвар, ёс зүйн түвшин тогтоох үзлэг явуулах, гуравдугаарт

Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийг анги, салбаруудад байгуулах зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байгаа талаараа танилцууллаа.

Ийнхүү Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хилийн цэргийн ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Хүний эрхийн үндэсний комиссын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэв.

ҮЙЛ ЯВДАЛ

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД "СОЁМБО" РЕДАКЦЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ УУЛЗЛАА

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өчигдөр "Соёмбо" редакцын бие бүрэлдэхүүнтэй уулзлаа. Тус редакцыг 97 жилийн түүхтэй "Соёмбо" сонин, 25 жилийн түүхтэй "Дуулга" студийн уран бүтээлчид бүрдүүлдэг бөгөөд өнгөрөгч оны сүүлчээр тус хоёр байгууллага удирдлага, зохион байгуулалтын хувьд нэгдэж, Төрийн батлан хамгаалах бодлого, түүний хэрэгжилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэд, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нийтлэлийн бодлогоо оновчтой тодорхойлон, нэвтрүүлэг, нийтлэлийн агуулга, чанар, мэдээллийн хурдан шуурхай байдалд тодорхой ахиц дэвшил гаргаж байгаад баяр хүргэж, ажлын амжилт хүслээ. Түүнчлэн "Батлан хамгаалах салбар, ялангуяа Зэвсэгт хүчний нэгтгэл, анги,

салбаруудад хүрч ажиллах, хугацаат цэргийн алба хаагчаас эхлээд ахлагч, офицер нарын ажил амьдралын гүнд орж тэдний талаарх бодит мэдээ мэдээлэл, сурвалжилгыг түлхүү хүргэж байгаарай. Аливаа дутагдал, доголдол, шударга бус байдлыг ил тод шүүмжлэн гаргаж, салбарынхаа хөгжил дэвшилд үнэний дуу хоолой нь болох үүргийг ч хүлээх ёстой. Ийм чуламжлалтай байсан. Социализмын үед "Улаан-Од" нэрээр хэвлэгдэж байхдаа ч баримтад тулгуурласан шүүмжлэлтэй сурвалжилга, нийтлэлүүдийг уншигчдад хүргэн энэ мөрөөр олон асуудал шийдэгдэж байсныг та бүхэн мэдэж байгаа. Сэтгүүлчид гэдэг бол нийгмийн хөдөлгөгч хүч, сайн сайханд уриалан дуудагч, бурууд нүд хурц хүмүүс. Хэдийгээр салбарын сонин, студи боловч та бүхнийг дөрөв дэх засаглалын үүргээ биелүүлж, Батлан хамгаалах салбарын хөгжил дэвшил, шинэчлэлийн төлөө дуу хоолойгоо хүргэхэд салбарын удирдлагын хувьд дэмжиж ажиллах болно" гээд тодорхой үүрэг чиглэл өглөө.

## 76 БАЙЛДААНЫ ОНГОЦ НЭГЭН ЗЭРЭГ ТЭНГЭРТ НИСНЭ



Ирэх сарын 9-нд Аугаа их Эх орны дайны ялалтын 76 жилийн ой тохионо.

Тухайн өдөр 76 байлдааны онгоцыг оролцуулахаар төлөвлөжээ. Үүнд 53 онгоц, 23 байлдааны нисдэг тэрэг багтаж байгаа бөгөөд бэлтгэл байдлыг сайтар хангасан гэдгээ Оросын Агаар-сансрын хүчнээс мэдээллээ. Кремлийн ордны хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков "Цар тахлын улмаас хүнд бэрх цаг тохионоод байгаа ч Нацист Германы халдлагыг нухчин дарсан

Аугаа их Эх орны дайны ялалтын баярын өдрийг ёслол төгөлдөр тэмдэглэхээр зэхэж байна" хэмээн ярьсан юм. Эх сурвалжийн мэдээлж байгаагаар коронавирусийн дэгдэлтээс улбаалж энэ жилийн ялалтын баярыг 6 дугаар сарын 24-нд товлоод байгаа юм. Тус улсын Ерөнхийлөгч В.Путины мэдэгдсэнээр 6 дугаар сарын 24-ний өдрийг сонгосон нь анхны ялалтын баярын цэргийн парад 1945 оны тус өдөр тохиож байсантай холбогдуулж ийнхүү сонгожээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
2°C	-8°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40°C	25°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
17°C	4 °C

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,319.0	3,384.0
CNY	432.30	436.70
RUB	36.87	38.66
JPY	25.47	26.09
KRW	2.46	2.60

### КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	394
НИЙТ БҮРТГЭГДСЭН	8841
ЭДГЭРСЭН	5070
НАС БАРСАН	12

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	22
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ	259
ЭДГЭРСЭН	1186
НИЙТ БАТЛАГДСАН	1447

### ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.04.02  
/БААСАН ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН ЦАГААН ЛУУ ӨДӨР

Үс засуулвал:  
ӨЛСӨЖ УНДААСНА  
Наран ургах, шингэх:  
06.29-19.23

Барилдлага: ШИД

Шүтэн барилдлага: ТӨРӨХҮЙ

Суудал: УС

Аргын тооллын 4 сарын 2, Сугар гараг. Билгийн тооллын 2, Эрхтний тэнгэрт одтой, цагаан луу өдөр. Өдрийн наран 6 цаг 29 минутад мандан, 19 цаг 23 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦАХИМ ШУУДАНД

# “ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО” СУРГАЛТАД ҮБХИС-ИЙН БАГ АМЖИЛТАЙ ОРОЛЦОВ

ҮБХИС



ШУТИС Боловсрол, шинжлэх ухааны яам, Сингапур улсын Темасек сан, Политехникийн их сургуультай хамтран “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо” хөтөлбөрийн таван багц сургалт зохион байгуулахаас эхний багц сургалтыг өнгөрсөн оны 11 дүгээр сараас эхлүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь дээд боловсролын чанарыг баталгаажуулах арга, зарчим, онцлог шилдэг туршлагыг хуваалцах боломж олгох, манай улсын дээд боловсролын орчинд тохирох чанарын баталгаажуулалтын хүрээ, аргуудыг тодорхойлох, загварчлах, тогтоох, боловсруулахад дэмжлэг үзүүлэх, чанарын баталгаажуулалтын

цуврал багц сургалтыг зохион байгуулж, мэдлэг түгээх мастер багш нарыг сонгон бэлтгэхэд чиглэж байгаа юм.

Уг хөтөлбөрийн 2 дахь багцын эхний сургалт “Засаглал ба манлайлал” сэдвийн хүрээнд цахимаар амжилттай явагдаж өндөрлөв. Сургалтад БШУЯ, ШУТИС, МУИС, ХААИС, СУИС, ҮБХИС, ТТДС, Тэнгэр дээд сургууль, МУБИС-ийн 50 гаруй багш, мэргэжилтэн оролцлоо. Сургалтад ҮБХИС-ийн дотоод чанарын баталгаажуулалтын орон тооны бус багийн гишүүд болох Багшийн хөгжлийн төвийн сургалт, арга зүйн ахлах мэргэжилтэн, профессор Я.Чойжамц, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Авто, хуягт танкийн тэнхимийн багш, хошууч Б.Мөнх-Эрдэнэ, Цэргийн хөгжмийн коллежийн Сургалт, уран сайхны ахлах офицер, ахмад Б.Сүх-Очир,

Дотоод аудит, чанарын албаны боловсрол, сургалтын чанарын үнэлгээний мэргэжилтэн, доктор (Ph.D) С.Дэнсмаа, Аюулгүй байдлын дээд сургуулийн ахлах багш, дэд профессор С.Мандалмаа нар сургуулиа төлөөлөн оролцсон юм.

Сургалтын явцад нэгдүгээрт, бидэнд их сургуулийн чанарын баталгаажуулалтын үндсэн чиглэлүүд, чанарын баталгаажуулалтын болон чанарын үнэлгээний аргуудын талаар Сингапурын Технологийн их сургуулийн тэргүүлэх профессорууд лекц уншин үндсэн мэдлэгийг олгож, чанарын баталгаажуулалтын үндсэн чиглэл бүрээр оролцогч их дээд сургууль бүрээр өөрийнх нь жишээн дээр тулгуурлан үнэлгээ, задлан шинжилгээ хийлгэж, арга зүйн чадварыг бататгалаа. Хоёрдугаарт, Монголын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсруулах, түүний зорилгыг тодорхойлох, дээд боловсролын байгууллагын чанарын арга хэмжээнүүдийг загварчлах, чанарын үзүүлэлтийг тодорхойлох, үйл явцын форматыг тодорхойлох хүрээнд сургалтад оролцогчдын арга зүйн чадварыг нэмэгдүүлэх, тэгэхдээ их сургууль бүрийн онцлог, туршлагыг хуваалцах боломж олгосноороо үр дүн, ач холбогдол өндөртэй сургалт боллоо.

Хөтөлбөрийн II багцын дараагийн сургалт энэ сарын 20-23-ны өдрүүдэд “Менеджмент ба стратегийн төлөвлөгөө” сэдвээр дөрвөн өдрийн хугацаанд онлайнгаар зохион байгуулагдахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байгаа аж.

## ХОЛЫН ЭРГҮҮЛИЙН БҮЛЭГ ҮҮРГЭЭ АМЖИЛТАЙ ГҮЙЦЭТГЭВТ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын UNMISS энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хурандаа Д.Энхбаатар захирагчтай Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн НҮБ-ын мандатаар заагдсан үндсэн үүргээ байгаль, цаг уурын хүнд нөхцөлд амжилттай үүрэг гүйцэтгэсээр байна.

Өмнөд Суданд хуурай халууны улирал үргэлжилж байгаа бөгөөд 42-53 хэмийн халуунд Юнити секторын томоохонд сууринд тооцогдох 120 гаруй мянган хүн амтай “Маёом” сууринд цэргийн багийн 2 дахь ээлжийн бүрэлдэхүүн 40 хоногийн хугацаанд холын эргүүлийн үүрэг гүйцэтгэлээ.

Тус холын эргүүлийн 2 дахь

бүлэг нь цэргийн багийн хариуцлагын бүсэд ойрын болон холын эргүүлийн үүргийг 8 чиглэлд давхардсан тоогоор 34 тосгон, сууринд нийтдээ 3500 гаруй км-ийн эргүүл хийсэн байна. Ингэхдээ цагийн байдлыг судлах, иргэн-цэргийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор орон нутгийн удирдлага, иргэдтэй уулзалт зохион байгуулж, тус бүс нутагт тогтвортой байдлыг тогтоон, энгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах үүргээ амжилттай гүйцэтгэсэн юм.

“Маёом” суурингийн шинээр томилогдсон захирагч нь Монгол цэргүүдийг тус сууринд холын эргүүлийн үүрэг гүйцэтгэж, орон нутгийн иргэдийн хамгаалахад тусламж дэмжлэг үзүүлсэнд талархал илэрхийлээд “Олон мянган жирийн иргэдийн бахархал бас амьд явах баталгаа нь цэрэг дайчид та бүхэн юм шүү” хэмээн онцолж байсан юм.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

## 15 КМ-ИЙН ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ

Зэвсэгт хүчний 123 дугаар анги



2020-2021 оны сургуулийн жилийн нэгдүгээр үеийн төгсөлтийн шалгалтыг бие бүрэлдэхүүнээсээ авлаа.

Шалгалт жагсаалын үзлэгээр эхэлж, дараагаар 15 км-ийн марш,

хүн нэг бүрийн буудлага, биеийн тамирын түвшинг тогтоов. Төгсгөлд нь тусгай үүргийн болон мэргэжлийн бэлтгэлийн шалгалт авч, алба хаагч бүрээр нь үнэлж дүгнэсэн юм. Мөн ангийн эмэгтэйчүүдийн санаачилгаар соёл хүмүүжлийн албанаас 1, 2, 3 дугаар сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийн баярыг тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ үеэр үлээвэр найрал хөгжмийн удирдаач, хошууч Ж.Ганбаатар, соёлын төвийн дарга, ахмад У.Батцэнгэл, Морьт сумангийн ротын цэргийн гэрээт алба хаагч байлдагч Д.Хосбаяр, Ц.Батбаяр, Э.Хэнчбиш нар ая дууны мэндчилгээ дэвшүүлэв. Мөн дайчдын ар гэрээс онлайнгаар мэндчилгээ илгээснийг энэ үеэр үзүүлээ.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

ХИЛИЙН ЧАНАДААС

# АФГАНИСТАН ЦЭРГҮҮДИЙН АМЬ НАСЫГ АВРАХАД МОНГОЛ ЦЭРГҮҮД ОНЦГОЙ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ



ИБНАУ-д явагдаж буй НАТО-гийн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн баг үүргээ амжилттай гүйцэтгэсээр байна.

ИБНАУ-ын нийслэл Кабул хотод өнгөрсөн сарын 30-нд алан хядагч террорист бүлэглэлүүдийн зүгээс Афганистаны олон нийтийг хамгаалах хүчний эсрэг чиглэсэн 3 удаагийн халдлага хийж, үүний улмаас 10 хүн үрэгдэж, 6 хүн шархадсан юм.

Кабулын аюулгүй байдлыг хангах хүчнээс Афганистаны үндэсний олон нийтийг хамгаалах хүчний шархадсан цэргийн 6 алба хаагчийг халдлага үйлдэгдсэн газраас татан гаргаж, хоёрдугаар шатны эмнэлэг рүү тээвэрлэх ажиллагааг зохион байгуулсан юм. Тодруулбал, Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бүрэлдэхүүн цагийн байдлыг үнэлж, шархтан тээвэрлэсэн техникийг шалган нэвтрүүлж, нисдэг тэргэнд

шилжүүлэн тээвэрлэх үүргийг богино хугацаанд шуурхай гүйцэтгэснээр шархадсан цэргийн алба хаагчид цаг алдалгүй эмнэлгийн тусламж авч чадсан.

Кабулын аюулгүй байдлыг хангах хүчний удирдлагаас Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багт гүн талархал илэрхийлсэн бөгөөд “Монгол цэргүүд сонор сэрэмжээ алдалгүй, цагийн байдлыг үнэлж, шуурхай ажилласанд баярлалаа. Цэргийн хүний гол зарчим чадварлаг үүрэг гүйцэтгэлээс гадна сонор сэрэмж, бие даан шийдвэр гаргах чадвар байдаг. Энэхүү чадварыг Монгол цэргүүд гарамгүй эзэмшиж чаджээ” гэсэн юм.

Мөн Афганистаны үндэсний олон нийтийг хамгаалах хүчний холбогч офицер шархадсан цэргийн алба хаагчдыг тээвэрлэх, шилжүүлэх ажиллагааны үед шуурхай ажиллаж, дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бүрэлдэхүүнд талархал илэрхийлэв.

Ахлах дэслэгч М.ТУЛГА

## ВАКЦИНЫ ЭХНИЙ ТУН ХАМГААЛАЛТ БИШ



Нийслэл хотын хэмжээнд одоогийн байдлаар 310 мянга гаруй хүн вакцинд хамрагдаад байна. Гэсэн хэдий ч цар тахлаар халдварлаж байгаа иргэдийн дунд вакцины эхний тун хийлгэсэн хүмүүс

өртөх тохиолдол гарч байгаа юм. Тодруулбал, вакцины эхний тун хийлгэсэн 532 хүн халдвар авчээ. Эхний тун хийлгээд 14 хоноод 40-50 хувийн дараагийн тунг хийлгээд мөн 14 хоноод дархлаа бүрэн тогтох юм. Вакцинаа хоёр тунгаар тариулсан ч амны хаалтаа тогтмол зүүж, зайгаа барьж, халдвар хамгааллаа сахихыг мэргэжлийн хүмүүс зөвлөсөөр байна.

Халдвар авсан иргэдийн 30 гаруй хувь нь ажлын байрнаасаа авч байгаа тул та бүхэн сонор сэрэмжээ алдаж болохгүй. Та бид ковид-19 халдвартай зэрэгцэн амьдарч буйг нэг хором ч бүү март.

ТАНЫ СОНОРТ

## E-MONGOLIA-Д НЭГДЭЖ АЛТАН ЦАГАА ХЭМНЭЭРЭЙ

Бүх үйлчилгээ	215
Барилгын инженерчлэлийн үйл ажиллагаа	1
Бизнес эрхлэлт	7
Боловсрол	6
Гэр бүл	18
Жолоодох эрх, тээврийн хэрэгсэл	11
Зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт акт	60
Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн	3
КОВИД-19	1
Нийгмийн хамгаалал	13
Нийтлэг хэрэглээ	11
Татвар, төлбөр тооцоо	43
Харилцаа холбоо	21
Хууль сахиулах	7
Хөдөлмөр эрхлэлт	6
Эдийн засаг, санхүү	2
Эрүүл мэнд	1
Үл хөдлөх эд хөрөнгө	4

Өнгөрөгч оны 10 дугаар сарын нэгэнд нээж байсан төрийн үйлчилгээний нэгдсэн платформ болох E-Mongolia 1 сая дахь иргэндээ үйлчилжээ.

Одоогийн байдлаар www.e-mongolia.mn хуудсанд төрийн 316 үйлчилгээ багтсан байдаг бөгөөд өдөр бүр шинэ үйлчилгээнүүд нэмэгдэж байгаа аж. Тодруулбал, ирэх сарын 9-нд болох Засгийн газрын 100 хоногт багтаан иргэдэд шаардлагатай 592 үйлчилгээг оруулах гэнэ.

Ингэснээр иргэд төрийн хүнд суртал, урт дараалалд зогсохгүйгээр төрийн үйлчилгээг гэрээсээ авахаас гадна баримт бичгүүдээ хүргүүлэх боломжтой болох юм.

**СОЁМБО СОНИН**  
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАДОРЖ

Дарга, ерөнхий редактор  
Хурандаа  
**САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Эхийг “Соёмбо” сониний редакцал бэлтгэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл бодол сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сониний мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Оффисруудын ордон  
Индекс 10018  
И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029